



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн хураангуй тайлан

Аудитын код: ЗАА-2026/080/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

"Алтан-Тосон аудит" ХХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: altantosonaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар сум, Завхан аймаг 81090
Утас-Факс: 7046-2612
Цахим хуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.16 № 172

Утасны № _____ -ийн № _____ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.ДОЛГОРСҮРЭН-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуульд Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас 32,224,043 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 28,020,000 төгрөгийн сурах бичиг, "Булнай оргил" төгсөгчдийн холбооноос 133,900,000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 17,969,080 төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан томилолтоор ажилласан албан хаагчдад 610,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан багш ажилчдын төрөөс олгох үзлэг, шинжилгээний төлбөрийг 4,166,000 төгрөгөөр илүү шилжүүлсэн, байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн санд батлагдаагүй хүний нөөц хариуцсаны нэмэгдэл 40 хувиар тооцож 5,228,394 төгрөгийг олгосон, тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш,

D:\Албан ёсны\А4-2026.docx

812605308

нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөөгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцолгүй, хийсэн ажлыг нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй 1,631,168 төгрөгийг олгосон, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт аймгийн Боловсролын газар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, "Эрдэмтэн сурагчдын хөгжлийн институт", "Алтайн жигүүр загвар зохион бүтээх" клуб, "Сэтгэлийн оньс академи" болон бусад чиглэлээр математик, мэдээлэл технологи, судлагдахуйн сургалтуудыг авч, сургалтын төлбөрт 16,924,000 төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	597,943,657.46	464,575,286.02
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	333,805,055.54	159,417,727.84
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	333,805,055.54	159,417,727.84
9	Төгрөг	333,805,055.54	159,417,727.84
10	Төрийн сангийн харилцах	333,805,055.54	159,417,727.84
27	АВЛАГА	0.00	2,376.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	0.00	2,376.00
60	БАРАА МАТЕРИАЛ	264,138,601.92	305,155,182.18
66	Хангамжийн материал	264,138,601.92	305,155,182.18
67	Бичиг хэргийн материал	4,525,000.00	4,297,450.00
68	Түлш шатах тослох материал	5,770,000.00	5,770,000.00
69	Барилгын засварын материал	1,771,000.00	1,771,000.00
72	Хүнсний материал	3,484,300.00	6,931,475.00
73	Бусад хангамжийн материал	248,588,301.92	286,385,257.18
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,657,022,620.53	4,575,432,924.43
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,657,022,620.53	4,575,432,924.43
108	Биет хөрөнгө	4,431,495,120.53	4,350,235,424.43
109	Барилга, байгууламж	4,479,295,245.00	4,461,419,325.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(643,333,025.74)	(753,659,525.02)
111	Авто тээврийн хэрэгсэл	45,000,000.00	45,000,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(5,250,000.00)
113	Машин, тоног төхөөрөмж	539,445,677.41	568,399,720.41
114	Хуримтлагдсан элэгдэл	(142,215,946.80)	(244,917,846.88)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	267,569,229.45	257,361,559.45
116	Хуримтлагдсан элэгдэл	(196,143,586.91)	(202,266,010.20)
122	Бусад үндсэн хөрөнгө	50,382,840.00	184,282,840.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(44,772,795.74)	(51,315,604.19)
125	Номын фонд	77,017,483.86	91,180,965.86
126	Биет бус хөрөнгө	225,527,500.00	225,527,500.00
127	Програм хангамж	2,832,000.00	2,832,000.00
128	Хасагдуулга	(2,502,000.00)	(2,832,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	225,197,500.00	225,197,500.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,254,966,277.99	5,040,008,210.45
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	119,539,260.00	42,498,510.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	119,539,260.00	42,498,510.00
164	Өглөг	119,539,260.00	42,498,510.00
170	Бусад өглөг	119,539,260.00	42,498,510.00
171	Байгууллагад төлөх өглөг	119,539,260.00	42,498,510.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,135,427,017.99	4,997,509,700.45
215	Засгийн газрын хувь оролцоо	5,135,427,017.99	4,997,509,700.45
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	616,475,838.51	616,475,838.51
217	Өмч: -Төрийн өмч	616,475,838.51	616,475,838.51
223	Хуримтлагдсан үр дүн	3,643,919,707.47	3,521,640,894.41
224	Өмнөх үеийн үр дүн	3,643,919,707.47	3,659,558,211.95

225	Тайлант үеийн үр дүн	-	(137,917,317.54)
226	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	875,031,472.01	859,392,967.53
230	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,254,966,277.99	5,040,008,210.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,537,100,359.00	5,012,255,362.01
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156,436,859.00	258,051,062.01
77	Нийтлэг татварын бус орлого	156,436,859.00	258,051,062.01
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,806,700.00	3,550,000.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,806,700.00	0.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	3,550,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	117,275,815.00	212,113,123.00
87	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	30,354,344.00	42,387,939.01
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,380,663,500.00	4,754,174,300.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	3,928,165,900.00	4,262,362,700.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,928,165,900.00	4,262,362,700.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	452,497,600.00	491,811,600.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	452,497,600.00	491,811,600.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,469,428,103.23	5,136,286,161.55
148	УРСГАЛ ЗАРДАЛ	4,469,428,103.23	5,136,286,161.55
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,241,179,296.95	4,889,377,262.52
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,967,446,098.69	3,460,231,089.52
151	Цалин	1,792,395,738.69	1,977,043,474.52
152	Нэмэгдэл цалин	987,754,460.00	1,242,011,173.00
153	Унаа хоолны хөнгөлөлт	-	98,290,000.00
154	Урамшуулал	187,295,900.00	142,886,442.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	372,556,957.74	433,258,377.36
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	249,212,957.74	291,336,977.36
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	30,836,100.00	35,480,000.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	15,417,900.00	17,740,300.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	15,417,900.00	17,740,300.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	61,672,100.00	70,960,800.00

164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	427,153,593.72	477,797,415.97
165	Гэрэл цахилгааны зардал	21,770,758.72	30,743,467.97
166	Түлш, халаалтын зардал	375,049,433.00	393,023,048.00
167	Цэвэр, бохир усны зардал	30,333,402.00	54,030,900.00
170	Хангамж, бараа материалын зардал	46,610,440.00	34,765,477.45
171	Бичиг хэргийн материал	9,148,530.00	4,113,190.00
172	Тээвэр шатахууны зардал	11,870,800.00	10,570,603.70
173	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	25,591,110.00	20,081,683.75
181	Нормативт зардал	79,503,565.00	93,285,405.00
182	Эм	440,400.00	-
183	Хоол	79,063,165.00	93,285,405.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	4,320,000.00	4,375,000.00
189	Урсгал засвар	4,320,000.00	4,375,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	46,890,738.63	49,910,396.12
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,806,700.00	-
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	42,084,038.63	49,910,396.12
209	Бараа үйлчилгээний бусад зардал	296,697,903.17	335,754,101.10
210	Бараа үйлчилгээний бусад зардал	34,640,070.00	36,070,000.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	30,441,100.00	19,837,800.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	231,616,733.17	279,846,301.10
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,248,806.28	246,908,900.03
228	Бусад урсгал шилжүүлэг	207,404,800.00	237,269,715.00
232	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	157,938,000.00	237,269,715.00
233	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	49,466,800.00	-
241	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,844,006.28	9,639,184.03
244	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,844,006.28	9,639,184.03
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	67,672,255.77	(124,060,799.54)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	13,856,518.00
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	13,856,518.00
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(13,856,518.00)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	67,672,255.77	(137,917,317.54)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,389,470,200.00	4,757,724,300.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,806,700.00	3,550,000.00
78	Нийтлэг татварын бус орлого	8,806,700.00	3,550,000.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,806,700.00	3,550,000.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,806,700.00	-
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	3,550,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,380,663,500.00	4,754,174,300.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	3,928,165,900.00	4,262,362,700.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,928,165,900.00	4,262,362,700.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	452,497,600.00	491,811,600.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	452,497,600.00	491,811,600.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	4,246,640,960.06	4,932,111,627.70
148	УРСГАЛ ЗАРДАЛ	4,246,640,960.06	4,932,111,627.70
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,018,392,153.78	4,685,202,728.67
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,967,446,098.69	3,460,231,089.52
151	Үндсэн цалин	1,792,395,738.69	1,977,043,474.52
152	Нэмэгдэл	987,754,460.00	1,242,011,173.00
153	Унаа хоолны хөнгөлөлт		98,290,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	187,295,900.00	142,886,442.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	372,556,957.74	433,260,753.36
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	249,212,957.74	291,339,353.36
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	30,836,100.00	35,480,000.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	15,417,900.00	17,740,300.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	15,417,900.00	17,740,300.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	61,672,100.00	70,960,800.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	427,153,593.72	477,797,415.97
165	Гэрэл цахилгааны зардал	21,770,758.72	30,743,467.97
166	Түлш, халаалтын зардал	375,049,433.00	393,023,048.00
167	Цэвэр, бохир усны зардал	30,333,402.00	54,030,900.00
181	Нормативт зардал	80,768,075.00	96,732,580.00

183	Хоол, хүнс	80,768,075.00	96,732,580.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,375,000.00
189	Урсгал засвар	4,500,000.00	4,375,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,890,738.63	49,910,396.12
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,806,700.00	-
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,084,038.63	49,910,396.12
206	Бараа үйлчилгээний бусад зардал	119,076,690.00	162,695,493.70
209	Бараа үйлчилгээний бусад зардал	88,635,590.00	143,057,693.70
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	30,441,100.00	19,837,800.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,248,806.28	246,908,899.03
225	Бусад урсгал шилжүүлэг	207,404,800.00	237,269,715.00
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	157,938,000.00	169,492,250.00
230	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	49,466,800.00	-
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,844,006.28	9,639,184.03
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,844,006.28	9,639,184.03
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	142,829,239.94	(174,387,327.70)
261		85,980,440.00	
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,980,440.00	-
263	Дотоод эх үүсвэрээр	85,980,440.00	-
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,980,440.00	-
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(85,980,440.00)	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	56,848,799.94	(174,387,327.70)
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	276,956,255.60	333,805,055.54
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333,805,055.54	159,417,727.84

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210	
2	2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	-101,356,598.22	1,390,150,712.30
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	-101,356,598.22	1,390,150,712.30
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	117,815,013.98	117,815,013.98
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,643,919,707.47	5,135,427,017.99

10	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,643,919,707.47	5,135,427,017.99
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0	15,638,504.48	15,638,504.48
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,659,558,211.95	5,151,065,522.47
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	-15,638,504.48	0	-15,638,504.48
17	Таилант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	-137,917,317.54	-137,917,317.54
18	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	616,475,838.51	859,392,967.53	3,521,640,894.41	4,997,509,700.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгсрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	333,805,055.54	(333,805,055.54)	-
2	I. НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,653,330,900.00	3,557,010,872.58	96,320,027.42	97.4%
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,653,330,900.00	3,557,010,872.58	96,320,027.42	97.4%
4	Бараа, үйлчилгээний зардал	3,653,330,900.00	3,557,010,872.58	96,320,027.42	97.4%
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,173,978,300.00	3,096,722,820.52	77,255,479.48	97.6%
6	Үндсэн цалин	2,013,373,200.00	1,824,938,775.52	188,434,424.48	90.6%
7	Нэмэгдэл	1,150,623,200.00	1,150,623,200.00	-	100%
8	Унаа болон бусад нөхөн олговор		89,435,000.00	(89,435,000.00)	
9	Урамшуулал	9,981,900.00	31,725,845.00	(21,743,945.00)	317%
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	396,747,400.00	386,504,453.36	10,242,946.64	97.4%
12	Тэтгэврийн даатгал	269,788,200.00	259,545,253.36	10,242,946.64	96.73
13	Тэтгэмжийн даатгал	31,739,800.00	31,739,800.00	-	100%
14	ҮОМШӨ ний даатгал	15,869,900.00	15,869,900.00	-	100%
15	Ажилгүйдлийн даатгал	15,869,900.00	15,869,900.00	-	100%
16	Эрүүл мэндийн даатгал	63,479,600.00	63,479,600.00	-	100%
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	487,436,600.00	477,797,415.97	9,639,184.03	98.00
18	Гэрэл цахилгаан	46,745,900.00	30,743,467.97	16,002,432.03	65.08
19	Түлш, халаалт	401,574,000.00	393,023,048.00	8,550,952.00	97.9
20	Газар, бохир ус	39,116,700.00	54,030,900.00	(14,914,200.00)	99.96
30	Нормативт зардал	106,069,600.00	96,732,580.00	9,337,020.00	91.2%
32	Хоол, хүнс	106,069,600.00	96,732,580.00	9,337,020.00	91.2%
34	Эд хогшил худалдан авах	4,375,000.00	4,375,000.00	-	100.00
38	Урсгал засвар	4,375,000.00	4,375,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	29,202,700.00	21,273,241.12	7,929,458.88	72.8
49	Мэдээллийн технологийн зардал	29,202,700.00	21,273,241.12	7,929,458.88	72.8
53	Бараа үйлчилгээний бусад зардал	45,148,400.00	45,146,443.70	1,956.30	100
54	Бараа үйлчилгээний бусад зардал	25,310,600.00	25,308,643.70	1,956.30	100

55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,837,800.00	19,837,800.00	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	239,889,000.00	237,269,715.00	2,619,285.00	98.9
70	Бусад урсгал шилжүүлэг	239,889,000.00	237,269,715.00	2,619,285.00	98.9
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	239,889,000.00	237,269,715.00	2,619,285.00	98.9
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,265,912,700.00	4,265,912,700.00		100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,262,362,700.00	4,262,362,700.00	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	4,262,362,700.00	4,262,362,700.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
104	Орон нутгийн төсвөөс	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,550,000.00	3,550,000.00	-	100
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,550,000.00	3,550,000.00	-	100
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	333,805,055.54	(333,805,055.54)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	159,417,727.84	(159,417,727.84)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
200	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
201	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
202	Бараа, үйлчилгээний зардал	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
215	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	487,436,600.00	477,797,415.97	9,639,184.03	100.00
216	Гэрэл цахилгаан	46,745,900.00	30,743,467.97	16,002,432.03	65.08
217	Түлш, халаалт	401,574,000.00	393,023,048.00	8,550,952.00	97.09
218	Цэвэр, бохир ус	39,116,700.00	54,030,900	(14,914,200.00)	138.1
232	Эд хогшил худалдан авах	4,375,000.00	4,375,000.00	-	100.00
236	Урсгал засвар	4,375,000.00	4,375,000.00	-	100.00
1765	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
1771	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00
1772	Орон нутгийн төсвөөс	491,811,600.00	482,172,415.97	9,639,184.03	98.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,635.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 6,859.6 мянган төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж өгч, 610.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,166.0 мянган төгрөгийн болон өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.1 Залруулсан алдаа байхгүй

3.2 Төлбөрийн акт:

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 610,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т

"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал" гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбарийн акт тогтоолоо.

3.3 Албан шаардлага:

Илрүүлэлт-1: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй болон эрүүл мэндийн үзлэгт хамруулсан багш, ажилчдын төрөөс олгох үзлэг шинжилгээний төлбөрийг тогтоосон нормоос 4,166,000 төгрөгөөр илүү төлсөн зөрчилд албан шаардлага өглөө.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцолгүй олгосон, хийсэн ажил нь тодорхойгүй, хичээлд суугаагүй тохиолдолуудыг бүртгэж тооцоо хийгээгүй, хийсэн ажлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй, баримтын бүрдэл дутуу баримтаар 1,631,168 төгрөгийн нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг журамд заасны 10 хувиар тооцож олгох, анхан шатны нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлж хэвших;

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын орон тоо цалингийн санд батлагдаагүй хүний нөөц хариуцсан гэх үндэслэлээр ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 40 хувиар тооцож, 5,228,394 төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллаж, батлагдаагүй хүний нөөцийн нэмэгдэл олгохгүй байх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу-лаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 610,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон байна.	1	610.0	1	610.0								
2025 оны эрүүл мэндийн үзлэгт хамруулсан багш ажилчдын төрөөс олгох үзлэг, шинжилгээний мөнгийг илүү шилжүүлсэн	1	4,166.0			1	4,166.0						
Орон тоо цалингийн санд батлагдаагүй хүний нөөц хариуцсан гэх үндэслэлээр хавсарсан нэмэгдэл 40 хувиар тооцож олгосон.	1	5,228.4					1	5,228.4				
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-						

Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцолгүй олгосон, хийсэн ажил нь тодорхойгүй хичээлд суугаагүй тохиолдолуудыг бүртгэж тооцоо хийгээгүй, хийсэн ажлыг нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй дутуу баримтаар нэмэгдлийг тооцож олгосон	1	1,631.2					1	1,631.2			
Дүн	5	11,636.6	1	610.0	2	4,166.0	2	6,859.6			

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

Огноо: 2026-02-24

БОЛОВСРУУЛСАН:

"АЛТАН ТОСОН АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Огноо: 2026-02-24



Ж.ТУНГАЛАГ

Б.ДАГВАСҮРЭН